

**БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЖ БАЙГАА НӨЛӨӨЛӨЛ, ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА
ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛ**

2023.04.19

№	Хийгдэх ажлууд	Хугацаа	Гүйцэтгэл	Биелэлт
1	Шатах, тослох материалын буулгалт, хадгалалтанд хяналт тавьж, нефтийн бүтээгдэхүүн хөрс, ус, агаарт алдагдахаас сэргийлж ажиллах	2023 онд	Нефтийн бүтээгдэхүүн хөрс ус агаарт алдагдахаас сэргийлж бак сав тоног төхөөрөмжийн битүүмжид байнга хяналт тавьж ажиллаж байна	30%
2	Нүүрсний тоос агаарт тархах, хадгалсан нүүрс шатахаас сэргийлэх	2023 онд	Нүүрсийг стандартын дагуу штабельдан нягтруулж уугих, агаарт хийсч бохирдуулахаас хамгаалсан арга хэмжээг авч ажиллаж байна	30%
3	Станцын үнсэн сангаас тоосжилт үүсч агаар, хөрсийг бохирдуулахгүй байхад анхаарах	2023 онд	Үнсэн сан №1 ажил энэ ондоо багтан дуусах төлөвлөгөөтэй ажиллаж байна. Үнсэн сан №2 тоосжилт үүсгэхгүйн тулд усан мандлаар барьж ажиллаж байна.	50%
4	Үнсэн сангийн хиймэл далангийн хөрсний гулсалт, нуралт үүсэх, байгаа эсэх, шүүрэлт гарч ус бохирдуулахаас сэргийлэх	2023 онд	Ус, хөрсний шинжилгээ хийлгэж байнга хяналт тавьж ажиллаж байна	30%
5	Үнсэн сан №1-ийг үнсийг зөөж суллах, нөхөн сэргээх ажлыг хийж дуусгаж ашиглалтанд оруулах, үнс хийсэхгүй байх тал дээр анхаарах	2023 онд	Үнсийг суллах ажил өмнө жил хийгдэж дууссан. 4-р сарын сүүлээр гэрээт компани ажил эхэлж энэ ондоо ашиглалтанд хүлээн авна. Тухайн гэрээт компани нь орчны бохирдол талаа хариуцан ажиллаж манай компани зүгээс хяналт тавьж ажиллаж байна	40%
6	Цехүүдийн байгаль орчны чиглэлээр хийсэн ажлыг хяналтын хуудсаар шалгах	2023 онд	Хяналтын хуудсаар үнэлгээг гаргахаар боловсруулалтын ажилууд явагдаад дуусах шатандаа явж байна	20%
7	Станцын ойр орчмын хөрс, ус, агаарт Орхон аймгийн УЦУОШГ-тай гэрээ байгуулж жилд 1-ээс доошгүй удаа шинжилгээ хийлгэж гарсан шинжилгээний дүнг холбогдох байгууллагуудад тайлагнаж ажиллах / БОАЖГ /	2023 онд	5 сард төлөвлөгөөний дагуу шинжилгээ хийлгэж, дүнг холбогдох байгууллагуудад албан бичгээр явуулж хамтран ажиллахаар бэлтгэл ажлуудыг хийв	-
8	Ажлын байруудад нарийн ширхэгтэй тоос РМ-2,5, химийн бодисын хэмжилт хөндлөнгийн байгуулагаар хийлгэх	2023 онд	төлөвлөгөөний дагуу 11 сард албан бичиг үйлдэж мэргэжлийн байгуулагатай хамтарч ажиллана	-
9	Гадна агаарын чанарын шинжилгээг станцын утааны хийн найрлагад РМ-2,5, РМ-10-г тодорхойлуулах	2023 онд	төлөвлөгөөний дагуу 10 сард албан бичиг үйлдэж мэргэжлийн байгуулагатай хамтарч ажиллана	-
10	Ахуйн болон аюултай хог хаягдал ангилан ялгаж тусгай саванд хадгалаж хот тохижуулах газартай байгуулсан гэрээний дагуу цаг тухай бүрт нь ачуулж хоггүй цэвэр орчинг бүрдүүлэх.	2023 онд	Тусгай зориулалтын саванд ангилан ялгаж гэрээт компаниудад цаг тухай бүрт нь өгч хамтарч ажиллаж байна. Химийн хорт бодисуудыг хариуцсан цех нэгжийн зориулалтын складанд хадгалж байна. Аймгаас өөрсдөө тусгай зөвшөөрөлтэй компани судалж, устгалд оруул гэсэн тул УБ хотын "Элемент" ХХК-тай холбогдон IV/19-ны өдөр албан бичиг явуулав	30%
11	БОАЖГ-аас жил бүр зохион байгуулдаг Байгаль хамгаалах хавар, намрын сарын аяны хүрээнд	2023 онд	4-р сарын сүүлийн 7 хоногт зохион байгуулахаар бэлтгэл ажилаа хангаж ажиллаж байна	20%

	зохион байгуулах эзэнгүй хог хаягдын цэвэрлэгээний ажилд идэвх санаачлагатай оролцож бүх албан хаагчдыг хамруулах.			
12	Станцын ойр орчмын 100 метр дотор цэвэрлэгээний ажлыг тогтмол хийж ажиллах /Зэрлэг өвс, ургамал, цас мөсийг арилгаж орчны цэвэрлэгээ болон аюулгүй байдлыг хангах/	2023 онд	Үерийн далан цэвэрлэх ажил явагдаж байна. Залгуулаад хариуцсан нэгж хэсгийн талбайн өнжмөл өвс, хог хаягдалыг цэвэрлэх ажил төлөвлөгөөний дагуу хийгдэж байна	30%
13	Ажиллаж байгаа зуухны утааны хийн найрлагад шинжилгээ хийж ажиллах	2023 онд	Горимын инженерээс өдөр бүр хяналт тавьж сардаа дундажыг гарган тайланг өгч ажиллаж байна.	30%
14	Усны найрлагад шинжилгээ хийлгэх /Гүний худгууд, түүхий ус, НОВ, голын ус /	2023 онд	Итгэмжлэгдсэн лаборатортоо өдөр бүр шинжилгээг хийж сараар нь нэгтгэн тайлагнаж ажиллаж байна	30%
15	Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд хашаанд үрслүүлсэн 4000 гаруй бургас модны суулгаж, дахин үрсэлгээ хийх	2023 онд	Мод үрсэлгээний "Тэ Эн" ХХК-тай хамтран ажиллах гэрээ 5-р сард дуусна Энэ 4000 суулгацаа 2 байрлалд хуваан суулгахаар болсон. Хөрсийг нөхөн сэргээгээд дахин үрсэлгээ хийхээр ажиллаж байна	20%
16	Цехүүдийн аюултай хог хаягдлын жагсаалт, журналын бүртгэлд хяналт тавин ажиллах	2023 онд	Шил, хуванцар савнууд, батарей гэх мэт хог хаягдалыг ангилан ялгах хогийн савнуудыг байрлуулж, бүртгэлийн журналд хяналт тавьж ажиллаж байна.	30%
17	Эм, эмийн анхан шатны тусламжийн хог хаягдлыг тусгай зөвшөөрөлтэй ААН-тэй гэрээ хийж нийлүүлж байх /Ногоон ариусгал ХХК/	2023 онд	Гэрээний дагуу 7 хоногт 1 удаа ирж хог хаягдалыг авч явж устгалд оруулж байна	30%

ХЯНАСАН:

БОЛОВСРУУЛСАН:

Б.ГАНБАТ

(ДХХ-ийн дарга)

Н.ЦЭНГҮҮНЖАВ

(Техник хяналтын инженер)